

БАТЛАВ.
ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.НАРАНТУЯА

**ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ШАЛГАЛТ
ТОХИРУУЛГА ХИЙХ ГЭРЭЭ**

Дугаар №.....

2017 06 06 087

201... оны сарын өдөр

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Энэхүү гэрээг Иргэний хуулийн 343-356 дугаар зүйл, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 249 дүгээр тушаалаар батлагдсан “Эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулга хийх журам”-ыг баримтлан нэг талаас Эрүүл мэндийн хөгжлийн төв (цаашид “Гүйцэтгэгч” гэх)-ийг төлөөлж Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны дарга Д.Тамир нөгөө талаас Говьсүмбэр аймгийн Баянтал сумын эрүүл мэндийн төв (цаашид “Захиалагч” гэх)-ийг төлөөлж дарга Б.Минсэл нар дараах нөхцөлийг харилцан тохиролцон байгуулав.

1.2 Гэрээ нь Захиалагчийн эмнэлгийн тоног төхөөрөмжид анхдагч болон ээлжит шалгалт тохируулга хийхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр. Захиалагчийн эрх үүрэг, хариуцлага

2.1 Тухайн эрүүл мэндийн байгууллагад ашиглаж байгаа эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгаанд үндэслэн ээлжит шалгалт тохируулгад эмнэлгийн тоног төхөөрөмжийг бүрэн хамруулна.

2.2 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгыг хийлгэхдээ дараах шаардлагыг бүрдүүлэн ажиллах нөхцөлийг хангаж ажлын өрөөг бэлтгэнэ. Үүнд:

✓ Шалгалт тохируулгад хамрагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийн бэлтгэл ажлыг хангах;

✓ Шаардлагатай үед гүйцэтгэгчийн симулятор, анализатор болон бусад хэрэгслийг шалгалт тохируулга хийх байранд хүргэх, буцаан хүргэх мөн ажлын шаардлагаар симулятор, анализаторыг өөрийн ажлын байранд хадгалах бол бүрэн бүтэн байдлыг хариуцах;

✓ Шалгалт тохируулга хийхэд хариуцан ажилладаг эмнэлгийн тоног төхөөрөмжийн инженер, техникч эсвэл ажилтанг хамтран ажиллуулах;

✓ Шалгалт тохируулгын өрөө нь зориулалтын газардуулгатай;

- ✓ Интернетийн сүлжээнд холбогдсон;
- ✓ Цахилгаан хамгаалалтын төхөөрөмжөөр бүрэн тоноглогдсон;
- ✓ Байгалийн болон зохиомол гэрэлтүүлэгтэй;
- ✓ Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуйн шаардлага хангасан утаа мэдрэгч, цэвэр, бохир усны системтэй байлгана;

2.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийг шалгалт тохируулгад хамруулахдаа дагалдах хэрэгслийн хамт бүрэн бүтэн хүлээлгэн өгнө.

2.4 Шалгалт тохируулгад тэнцээгүй эмнэлгийн тоног төхөөрөмжид засвар үйлчилгээ, засвар тохируулга хийж, шалгалт тохируулгад хамрагдсан өдрөөс эхлэн 2 сар хүртэлх хугацаанд ээлжит шалгалт тохируулгад хамруулна.

2.5 Шалгалт тохируулгад тэнцээгүй эмнэлгийн тоног төхөөрөмжийг ашиглахыг хориглоно.

2.6 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын төлбөрийн тооцоог Монгол Улсын Шадар сайдын 2015 оны 117 дугаар тушаалын дагуу зохих төлбөрийг төлнө.

2.7 Захиалагч нь эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хийсэн ажлын хөлсөнд 281,000 төгрөгийг нэхэмжлэх хүргүүлснээс хойш ажлын 5 хоногт багтаан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Төрийн сангийн 100900020020 тоот дансанд (ЭМХТ регистр 9086331) нэхэмжлэхийн дагуу шилжүүлнэ.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг, хариуцлага

3.1 Эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч, Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд тухайн тоног төхөөрөмжийн тоо ширхэг, бүрэн бүтэн байдлыг хариуцна.

3.2 Захиалагчтай байгуулсан гэрээ, хуваарийн дагуу эмнэлгийн тоног төхөөрөмжийн шалгалт тохируулга хариуцсан мэргэжилтэн стандарт, аргачлалын дагуу шалгалт тохируулгыг хийж гүйцэтгэнэ.

3.3 Эмнэлгийн тоног төхөөрөмжийн анхдагч болон ээлжит шалгалт тохируулгын ажлыг гүйцэтгэхдээ баталгаажуулсан симулятор болон анализаторыг ашиглана.

3.4 Талуудын тохиролцсон хугацаанд буюу 2017 оны 6 дугаар сарын 6-ны өдөр шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэхдээ чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэнэ.

3.5 Тухайн шалгалт тохируулгад хамрагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж тус бүрээр үр дүнгийн хуудас боловсруулан захиалагчид албан бичгээр хүргүүлнэ.

3.6 Хэрэв захиалагчийн эмнэлгийн тоног төхөөрөмжид шалгалт тохируулгын ажлыг хийж гүйцэтгэх хугацааг сунгах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ тухай мэдээллийг захиалагчид амаар болон бичгээр мэдэгдэнэ.

Дөрөв. Бусад зүйл

4.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд гэрээгээр тохиролцсон ажлыг гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчинтэй байна.

4.2 Гэрээний хугацаа дуусгавар болсны дараа захиалагч нь гэрээний гүйцэтгэлийн тайланг дараа оны гэрээ, хуваарь, эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааны хамт гүйцэтгэгчид албан ёсоор ирүүлж, талууд гэрээний хэрэгжилтийг хамтран дүгнэнэ.

4.3 Гэрээг гурван хувь үйлдэн хоёр хувийг гүйцэтгэгч, үлдэх хувийг захиалагч хүлээн авна.

4.4 Ажил гүйцэтгэх хавсралт нь гэрээний салшгүй хэсэг бөгөөд захиалагчийн хүсэлтээр гүйцэтгэх ажилд нэмэлт, өөрчлөлт оруулсан орсон тохиолдолд ажил үйлчилгээний төлбөрийн асуудлыг нэмэлт гэрээгээр тухай бүрд зохицуулж шийдвэрлэнэ.

4.5 Энэхүү гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүссэн маргааныг талууд зөвшилцөн шийдвэрлэнэ. Эс зөвшилцвөл асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Гүйцэтгэгч байгууллагыг төлөөлж:


Эмнэлгийн тоног төхөөрөмжийн албаны
даргын албан үүргийг түр орлон
гүйцэтгэгч



Д.Тамир

Захиалагч байгууллагыг төлөөлж:

Дарга



Б.Минсэл